

СҮХБААТАР АЙМГИЙН УГСААТНЫ ЗҮЙН МУЗЕЙН 2024 ОНЫ III-Р УЛИРЛЫН ТАЙЛАН

1. СОЁЛЫН ӨВИЙН ЧИГЛЭЛЭЭР:

1.1. Зохион байгуулсан үзэсгэлэн

Монгол улсад банкны тогтолцоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан Төрийн банктai хамтран “Буурлын хобби-2” үзэсгэлэнг 2024 оны 07.24-30-ны хооронд музейн үзэсгэлэнгийн түр танхимд дэглэсэн. Үзэсгэлэнд Сүхбаатар аймгийн Уулбаян сумын уугуул, цуглуулагч Я.Лхагвасүрэнгийн мөнгөн тэмдэгт, зоос, тэмдэг, картын 10000 гаруй нэр төрлийн цуглуулга болох эд өлгийн зүйлсийг дэглэж тус үзэсгэлэнг 322 иргэн үзсэн.



Эх хэлний өдөрт зориулсан “Эх хэл-Үндэсний дархлаа” сэдэвт үзэсгэлэнг түр үзэсгэлэнгийн танхимд 2024.09.01-09.08 хүртэл дэглэж, үзэсгэлэнд 6 ширхэг их хаадын захидал, ЕБС-ийн багш сурагчдын 8 бүтээл, “Жаахан шаргын нутаг-2024” уралдаанд оролцогчдын 98 бүтээл нийт 112 эд өлгийн зүйлийг дэглэж 90 үзэгч үзсэн.

1.2. Нээлттэй хаалганы өдөрлөг

Соёл урлагийн ажилчдын өдөр соёлын орон зай нээлттэй хаалганы өдөрлөгийг Жаахан шарга театрын ард талбайд зохион байгуулж “Мэргэжлийн холбогдолтой ном товхимол”-ыг дэглэн үзүүлж, соёлын өвийн тухай ойлголт мэдээлэл болон байгууллагын үйлчилгээний тухай мэдээллийг 400 гаруй иргэдэд өгч ажиллаа.



1.3. Музейн сан хөмрөгийн баяжилт болон эрдэм шинжилгээ, судалгааны ажил



Цуглуулагч Ц.Батсайханы хүлээлгэн өгсөн ШУА-н Археологийн хүрээлэнгээс судалгааны баг ирж цуглуулагч Ц.Батсайханы хүлээлгэн өгсөн эд өлгийн зүйлсийг 4-н талт зургийг авч, эд өлгийн зүйлийн он цаг, зориулалт зэргийг тодорхойлуулах ажлыг хийж гүйцэтгэв. Орчин цагийн музей үүсч хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулсан эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэл музейн эрдэм шинжилгээний ажилтан О.Ариунжаргалын “Музейн модон үзмэр эд, өлгийн зүйлийн хадгалалт хамгаалалт, аюулгүй байдалд тавигдах шаардлага”, Арга зүйч Ж.Наранчимэгийн “Музейн үзмэрийн баяжилтад хамтын ажиллагаа нөлөөлөх нь” сэдэвт илтгэлүүд Музей-100 эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд нийтлэгдсэн.

Арга зүйн зөвлөлийн хурлаар 46 дэсийн 46 ширхэг эд өлгийн зүйлийг бүртгэн баримтжуулан сан хөмрөгт баяжилт хийхээр шийдвэрлэж, эдгээр эд өлгийн зүйлст эрдэм шинжилгээний тодорхойлолт бичиж, музейн үзмэр эд өлгийн зүйлсийг бүртгэн баримтжуулах заавар маягтын дагуу бүртгэн баримтжуулалт хийж, холбогдох журмын дагуу үнэлгээ тогтоож ажилласан.

1.4. Музейн боловсролын ажил



Аймгийн баяр наадмын өдрүүдэд наадмын талбайд СУАЖЗГ-н газартай хамтран “Өөшхөө” боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэн тус хөтөлбөрт 129 хүүхэд хамрагдсан.

1.5. Музейн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл

Зөвшөөрлийн тухай хуулийн дагуу 8.1 дүгээр зүйлийн 7.5, Музейн тухай хуулийн 5 дугаар зүйлийн дагуу холбогдох баримт бичгийн бүрдлийг ханган ССАЖЗ-н яаманд хүргүүлснээр 8-н жилийн хугацаатай музейн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг гардан авлаа.



Музейн 100 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдсан чуулганд 9-н албан хаагчийн бүрэлдэхүүнтэй оролцож, байгууллагын товч танилцуулга болон онцлох үзмэрийн танилцуулгыг бэлтгэн хүргэсэн. Мөн удирдамжийн дагуу Бөхийн барилдаан, Үндэсний хувцастай хос, волейболын тэмцээн, үндэсний сурын харваа зэрэг тэмцээн уралдаанд амжилттай оролцсон.

2.АЛБАН ХААГЧДЫН СУРГАЛТ БОЛОН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ЧИГЛЭЛЭЭР

2.1. Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах

Албан хаагчдын эрүүл мэндийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг шинжилгээнд Улаанбаатар хотын NURA төвд 32 үзүүлэлттэй бүхий багц шинжилгээг нэг албан хаагч 980,0 төгрөгийн төлбөртэй уг төлбөрөөс байгууллага нэг



албан хаагч бүрд 721,5 төгрөгийн хөнгөлөлт үзүүлэн нийт 4,955,000 төгрөг зарцуулсан.

Тайлант хугацаанд давхардсан тоогоор 12 албан хаагчид 5,564.5 мян.төгрөгийн ур чадварын нэмэгдэл, 7 албан хаагчид 3,140.5 мян.төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон.

2.2. Сургалт

Аймгийн Засаг даргын тамгын газрын Залуучуудын хөгжлийн төвийн ахлах мэргэжилтэн А. Магадцэцэг “ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДАЛ” сургалтыг манай хамт олонд зохион байгууллаа.



Сумдын

бүртгэл мэдээллийн санчдыг чадавхжуулах сургалтыг цахим байдлаар дараах Соёлын өвийн хууль эрх зүйн орчин, Монгол улсын түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлийн бүртгэл хөтлөх заавар, Бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх нь (БМСанчийн үүрэг), Сан хөмрөг дэх цуглуулгын арчлан хамгаалалт ба хадгалалт, Монгол улсын түүх, соёлын хөдлөх

дурсгалт зүйлийн бүртгэл хөтлөх заавар сэдвийн хүрээнд зохион байгуулж 7-н сумын бүртгэл мэдээллийн санч хамрагдсан.

Сүхбаатар аймгийн хүүхэд гэр бүл залуучуудын газраас байгууллагын эцэг эхийн зөвлөлийн үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилготой “Бүтээмжтэй байгууллага-Хариуцлагатай эцэг эх сэдэвт сургалтад эцэг эхийн зөвлөлийн гишүүн 2 албан хаагч хамрагдсан. Мөн Эцэг эхийн зөвлөлөөс нийт албан хаагчдад ахмад багш Алтанцэцэгээр “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдэвт



сургалтыг зохион байгуулж 18-н албан хаагч хамрагдсан.



Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвөөс зохион байгуулсан “Монгол улсын кибер аюулгүй байдлын өнөөгийн нөхцөл байдал” сэдэвт сургалтад 5-н албан хаагч хамрагдлаа.

3.ЗӨВЛӨН ТУСЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Соёл, урлагийн үйл ажиллагаанд зөвлөн туслах, хяналт тавих, эрсдлээс урьдчилан, удирдлага арга зүйгээр хангаж дэмжлэг үзүүлэх зорилгоор Соёл, Урлаг, Аялал жуулчлал, Залуучуудын газрын даргын тушаалаар батлагдсан ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажиллаа.



4.АЛБАН БИЧИГ

- Ирсэн бичиг - 26
- Явсан бичиг - 11
 - Хариутай бичиг – 10
 - Хугацаандаа явсан бичиг – 8
 - Хугацаа болоогүй бичиг – 1
 - Хугацаа хэтэрсэн бичиг – 0

5.ТАЙЛАН, МЭДЭЭ

- Сар бүрийн 25-ны дотор СУАЖЗ-н газарт гарын үйл ажиллагааны мэдээг хүргүүлэн ажиллаж хэвшсэн.
- Сар бүрийн 5-ны өдрийн дотор Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг Монгол хэлний тухай хуулийн хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай /Засгийн газрын тогоол/, 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 23 дугаар тэмдэглэл / 2023-05-31 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, 2023 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 дугаар тэмдэглэл / 2023-11-08 / ЗГ-ын хуралдааны тэмдэглэл, “Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай / 2023-04-17 / ЗГ-ын албан даалгаврыг хяналтдаа авч хэрэгжилтийг тайланг хугацаанд нь Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим санд тайлагнан ажилласан.
- 2024 оны 03 сарын 01-ний өдөр Аймгийн Засаг даргын орлогч, Хэлний бодлогын салбар зөвлөлийн даргын баталсан Сүхбаатар аймгийн төрийн албан хаагчийн монгол, хэл бичгийн чадварыг дээшлүүлэх, 2025 онд хос бичигт шилжих бэлтгэлийг бүрэн хангах зорилго бүхий “Хос бичигтэн байгууллага” уралдааны удирдамжийн дагуу уралдаанд оролцож 10 арга хэмжээг хэрэгжүүлэн тайлан мэдээг заасан хугацаа болох 09 дүгээр сарын 11-нд хүргүүлэн ажилласан.

6. ТӨСӨВ САНХҮҮ

Улсын болон орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 123,841.3 мян. төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлого 6,952.8 мян.төгрөг, нийт 130,794.1 мян.төгрөгийн орлогыг хүлээн зөвшөөрч 93 удаагийн ажил гүйлгээгээр 152,913.0 мян.төгрөгийн урсгал зардлын зарлага санхүүжилтийг зарцуулж харилцах дансны үлдэгдэл 30,364.6 мян.төгрөгөөр илэрхийлэгдлээ.

Урсгал үйл ажиллагааны санхүүжилт болон үйл ажиллагааны өөрийн орлогоос 840.0 мян.төгрөгийн тоног төхөөрөмжийг худалдан авч зарлага санхүүжилтийг хийсэн. Мөн Соёлын яамнаас улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 7,265.2 мян.төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч нийт үндсэн хөрөнгө нэмэгдүүлж ажилласан.

Орчин цагийн музейн үүсэж хөгжсний 100 жилийн ойн баярын хүрээнд Өвөрхангай аймгийн Хар хорин суманд зохион байгуулагдсан Музей -100 нэгдсэн уулзалт зөвлөгөөнд нийт 9 албан хаагчийг оролцуулж томилолтын зардал болон тээвэр шатахууны зардалд өөрийн үйл ажиллагааны орлогоос 3,070.0 мян.төгрөгийн зарлага санхүүжилтийг хийсэн. Мөн Соёл урлагын ажилчдын баярын өдөрлөг арга хэмжээнд үйл ажиллагаагаа сурталчлах, албан хаагчдыг алдаршуулж шагнаж урамшуулах зардалд 570.0 мян.төгрөгийн төсөв хөрөнгийг тус тус зарцуулж ажилласан.

ДҮГНЭЛТ

Орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн ойн хүрээнд төлөвлөгөө боловсруулан ажиллаж иргэдэд соёлын боловсрол олгох хөтөлбөр, үзэсгэлэн, нээлттэй хаалганы өдөр зэрэг соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулж, музейн сан хөмрөгийн баяжуулах бүртгэн баримтжуулах, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн ажилласан.

Музейн тасалбарыг нэг удаа музей үзэх 5000 төгрөгийн тасалбар, гэр бүлээрээ /2 насанд хүрэгч/ музей үзэх тасалбар, музей үзэх гэрэл зураг авах, Дарьганга дээл өмсөж зураг даруулах, байгууллагын бүртгэл мэдээллийн сангаас лавлагаа авах гэсэн 5-н төрлөөр төрөлжүүлэн иргэдэд үйлчилж байна. 3 дугаар улиралд 169 иргэнд бэлэн бус тооцооны хэрэгсэл буюу пос машин ашиглан төлбөр хураамжийг авч 845,000 төгрөгийн тасалбар борлуулан ажилласан байна. Музейн үйлчилгээ иргэдэд тав тухай хүргэх, байгууллагын үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах зорилгоор түр үзэсгэлэнгийн танхим болон ариун цэврийн өрөөнд засвар үйлчилгээ хийж, цоорсон паарнуудыг шинэ паараар сольж тавьсан байна.

ТАЙЛАН БИЧСЭН: АРГА ЗҮЙЧ

(Ж.НАРАНЧИМЭГ)

ХЯНАСАН: ЗАХИРАЛ

(Д.АРИУНДЭЛГЭР)